



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2008 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Оюутны шигшээ багийн бүрэлдэхүүн,
цалинг батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 189 дүгээр тогтоол, "Биеийн тамир, спортын тухай" хуулийн 18.6, 18.7 дугаар заалт, нийслэлийн Засаг даргын 2007 оны 621 дүгээр захирамжийг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Нийслэл, дүүргийн хэмжээнд оюутны болон өсвөрийн шигшээ баг байгуулах, санхүүжүүлэх үйл ажиллагааны журмын 3.2 дугаар заалтаар сонгон шалгаруулсан оюутны шигшээ багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Хоёр. Шигшээ багийн ахлах дасгалжуулагчийн үндсэн цалинг "Төрийн албан хаагчдын албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2007 оны 351 дүгээр тогтоолын 9 дүгээр хавсралтын ТҮ-6-2 дугаар шатлалаар, бусад дасгалжуулагчдын үндсэн цалинг ТҮ-6-1 дүгээр шатлалаар, тамирчдын цалинг "Биеийн тамир, спортын тухай" хуулийн 18.7 дугаар заалтад Биеийн тамир, спортын Улсын хорооны даргын 2008 оны 11 дүгээр тушаалаар баталсан Залуучуудын шигшээ багийн тамирчдын сарын үндсэн цалингийн жишигт нийцүүлэн тогтоож хоёрдугаар хавсралтаар баталсугай.

Гурав. Оюутны шигшээ багийн дасгалжуулагч, тамирчдыг 2008 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн цалинжуулахыг нягтлан бодогч /Ж.Цэдэнсодном/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Шигшээ багийн сургалт, дасгалжуулалтыг батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу чанартай зохион байгуулж, үр дүнтэй ажиллахыг дасгалжуулагч нарт, шигшээ багийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг ахлах мэргэжилтэн /А.Болдмаа/-д үүрэг болгосугай.




ДАРГА

Ж.ГАНБОЛД

25
21


НБТСХ-ны даргын 2008 оны 03 дугаар сарын
04-ны өдрийн 11 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



**ОЮУТНЫ ШИГШЭЭ БАГИЙН ДАСГАЛЖУУЛАГЧ,
ТАМИРЧДЫН БҮРЭЛДЭХҮҮН**

№	Спортын төрөл	Дасгалжуулагчид	Тамирчид	Тоо
1.	Оюутны шигшээ багийн Ахлах дасгалжуулагч Чөлөөт бөх	Ц.Нацагдорж /МУГТ/	Т.Одбаяр /66 кг/ Б.Заяамандах /84 кг/ Г.Ганням /96 кг/ Я.Алтантулга	5
2.	Жудо бөх	О.Болд-Эрдэнэ /СМ/	Д.Дөлгөөн /ОУХМ, 66 кг/ Э.Тулга /ОУХМ, -90 кг/ Э.Сугаржаргал /СМ, +100 кг/ Д.Төмөрхүлэг	5
3.	Бокс	Р.Чинбат /СМ/	Ц.Ганхуяг /54 кг/ А.Бат-Очир /60 кг/	3
4.	Ширээний теннис	---	Л. Алтантулга /СМ/ Б. Батхишиг	2
5.	НИЙТ	3	12	15

НБТСХ-ны даргын 2008 оны 03 дугаар сарын
04-ны өдрийн 11 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт



**ОЮУТНЫ ШИГШЭЭ БАГИЙН ДАСГАЛЖУУЛАГЧ,
ТАМИРЧДЫН ЦАЛИН**

№	Дасгалжуулагч, тамирчдын нэрс	Спортын төрөл	Цол, зэрэг	Сарын үндсэн цалин
1.	Ц. Нацагдорж	Чөлөөт бөх	МУГТ	210.797
2	О. Болд-Эрдэнэ	Жудо бөх	СМ	104.345
3	Р. Чинбат	Бокс	СМ	156.518
4.	Т. Одбаяр	Чөлөөт бөх	-	150.000
5.	Б. Заяамандах	Чөлөөт бөх	-	150.000
6.	Г. Ганням	Чөлөөт бөх	-	150.000
7.	Я. Алтантулга	Чөлөөт бөх	-	50.000
8.	Д. Дөлгөөн	Жудо бөх	ОУХМ	60.000
9.	Э. Тулга	Жудо бөх	ОУХМ	60.000
10.	Б. Сугаржаргал	Жудо бөх	СМ	75.000
11.	Д. Төмөрхүлэг	Жудо бөх	-	50.000
12.	Ц. Ганхуяг	Бокс	-	150.000
13.	А. Бат-Очир	Бокс	-	150.000
14.	Л. Алтантулга	Ширээний теннис	СМ	150.000
15.	Б. Батхишиг	Ширээний теннис	-	150.000
НИЙТ ДҮН:				1.816.660